

## ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХЯМРАЛ НАМЖТАЛ ГУРВАН ЖИЛ БОЛОХ НЬ

Дэлхийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2009 онд уналттай байгаа боловч 2011 оноос л сэргэж эхлэнэ хэмээн Олон улсын валютын сан дүгнэсэн байна. Харин орос шинжээчид эдийн засгийн хямрал удаан үргэжилнэ гэж тооцоолжээ.

Сүүлийн үеийн статистик тоо баримтуудаас харахад Олон улсын валютын сан (ОУВС) энэ жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дүгнэлтээ дахин эргэж харах хэрэгтэй болж магадгүй нь.

Жилээс жилд ОУВС-г дүгнэлтээ хоёр сард нэг удаа шинэчлэхэд хүргэж байна. Тус сан 2008 оны арваннэгдүгээр сард энэ жилийн эдийн засгийн өсөлтийг 2,2 хувиар, 2010 онд 3,8 хувиар тус тус өснө гэж мэдэгдэв. Оны эхний нэгдүгээр сард ОУВС дүгнэлтээ 0,5 ба 0,8 хувиар дахин бууруулсан юм. Дэлхийн эдийн засгийг хямралаас гарахад гол бэрхшээл баян орнуудад үүсээд байна.

Өндөр хөгжилтэй орнуудын дотоодын нийт бүтээгдэхүүний бууралт нь дэлхийн хоёрдугаар дайны дараах үеийн үзүүлэлттэй адил болжээ. 2011 оны эхний хагас жилээс нааш эдийн засаг тогтвортой өсөхгүй гэж ОУВС-гийн зохицуулагч захирал Жон Липскийн хэлснийг “Reuters” агентлаг дамжуулжээ. “Манай мэдээгээр ДНБ-ний өнгөрсөн жилийн IV улирал, энэ жилийн I улирлын үзүүлэлт нь хамгийн эрчимтэй байсан. Дайны дараах үед бид тийм зүйлийг харж болох байлаа” гэж хэлсэн юм. 2008 оны IV улиралд евро бүсийн уналт нь өмнөх улиралтайгаа харьцуулахад 1.5 хувиар буурсан байв. Энэ нь 1995 оноос хойших хамгийн доод үзүүлэлт. Японы эдийн засгийн уналт гурван улирал дараалан өмнөх оны үеийнхээсээ 3.3 хувиар, АНУ-ынх сүүлийн 26 жилд хамгийн бага болох 6.2 хувиар тус тус буурсан байв. Эдгээр тоо баримтад үндэслэн “Goldman Sachs Group” төвийхэн дэлхийн эдийн засгийн үзүүлэлт буурч байгаа ч энэ нь хамгийн доод цэгтээ хүрээгүй гэдгийг анхааруулжээ. Тэд дэлхийн эдийн засгийн бууралт 0.2 хувьтай байна гэснээ засан 0.6 хувь болно гэв. “Эдийн засгийн байдал өмнөхийн адил асуудалтай, тодорхойгүй байдалд байна” гэжээ. Өндөр хөгжилтэй орнуудын эдийн засгийн уналт нь ёроолдоо хүрээгүй гэдэгтэй Оросын шинжээчид санал нэг байгаа аж. “ОУВС-гийн үнэлгээ нь бодит бөгөөд хэрэв байдал өнөөгийнхөөс дордохгүй бол улс орнуудын авч байгаа хямралын эсрэг арга хэмжээ нь үр дүнгээ өгч эхлэнэ” хэмээн “Ренесанс Капитал” судалгааны төвийн гүйцэтгэх захирал

Алексей Моисеев ярьжээ. “Сэргэлт хэзээ эхлэхийг хэлэхэд бэрх. Гэхдээ үл бүтэх мэт байсан зүйлс биеллээ олдог тохиолдол бий шүү дээ” гэж тэр хэлэв. “Малакут” гэх даатгал, брокерын конторын захирал Андрей Локшины хэлснээр эдийн засгийн өсөлт 2008 оноос хойших гурван жилдээ гарахгүй ба тэрбээр өөрийн дүгнэлтийг “Санхүүгийн пирамидийн зээлийн дүүргэлтийн төвшин одооноос л ойлгомжтой болж байна. Ажил хэргийн түр зуурын идэвхийг үл тооцох аваас урт хугацааны өсөлтийн эхлэл 2014-2015 онд гарна” хэмээн тайлбарлав. Яг тэр үеэр л дэлхийн эдийн засаг тогтворжиж эхэлнэ гэж түүнтэй “Альпери” төвийн шинжээч санал нэг байв. Оросын бас нэг шинжээч Сергей Фундобный “Уналтын үечлэл түүний үр дагавар наад зах нь таван жил орчим үргэлжилнэ” гэж дүгнэсэн.

Хэд хэдэн нөхцлийг биелүүлсэн тохиолдолд эдийн засаг сэргэж эхлэх ёстой. “Мөнгө зээлийн ба татвар, төсвийн бодлого нийтлэг эрэлтийг дэмжихэд улам нарийн чиглэсэн байх ёстой” гэж ОУВС-гийн илтгэлд тэмдэглэжээ. Дэлхийн эдийн засагт сэргэлт гарахын тулд өнөөгийн үйл ажиллагааны системийг нарийвчлан авч үзэх шаардлагатай байгааг шинжээчид бас хэлсэн юм. Бүх хохиролыг тогтоох, эрсдлийг удирдах болон зээлийн бодлогоо эргэн харах нь зүйн хэрэг. Энэ бүгд нь их цаг хугацаа шаардах нь ойлгомжтой. Янз бүрийн салбар, янз бүрийн цаг хугацаанд сэргээгдэнэ. Эхний ээлжинд эрэлттэй салбар болох цахим бараа, авто машины үйлдвэрлэл, түүний сэлбэг, агаарын тээвэр, аялал жуулчлал, мебелийн зэрэг салбаруудад өсөлт гарах ёстой. Түүнийг дагаад нефть, байгалийн хий болон түүхий эдийн салбар хөгжинэ гэж шинжээчид үзэж байна.

Харин ямар оронд сэргэлт түрүүлэн эхлэх вэ гэдэгт шинжээчид өөр өөр бодолтой байгаа. “Эхний ээлжинд АНУ, Япон, Европ зэрэг хөгжилтэй орнуудад эдийн засгийн сэргэлт явагдах байх. Хөгжилтэй орнууд эдийн засгаа сэргээн эрэлтийг үүсгэснээр хөгжиж буй орнуудын үйлдвэрлэл өсөх болов уу. Ер нь бол хямралаас өмнө хэрэглээ ихээхэн хөгжсөн байсан орнуудад л сэргэлт эхлэнэ гэхэд алдахгүй байх” дэлхийн эдийн засгийн хямралын асуудлыг тухайлсан бүс нутгуудад дээд хэмжээний уулзалтуудыг зохион байгуулах хэрэгтэй гэжээ.

*Эх сурвалж:* <http://www.vsesmi.ru/>

*Орос хэлнээс орчуулсан: Г.Онон  
(ОУСХ-гийн эрдэм шинжилгээний ажилтан)*